



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 он дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 128/125

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

“МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК” ТӨААТҮГ-Т

Худалдан авах ажиллагааны 2020 оны
хэрэгжилтэд үнэлгээ өгсөн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын 2020 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам (цаашид “журам” гэх)-ын дагуу үнэлгээ хийлээ.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 5.2.2-т заасан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр дамжуулан бүх худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулах чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн тул 2020 оны худалдан авах ажиллагааны үнэлгээг цахим системийн ашиглалттай уялдуулан хийсэн болно.

Танай ирүүлсэн тайлан болон холбогдох бусад материалд үндэслэн 2020 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 100 хувь бүхий шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 58 хувь авч “Хангалтгүй” гэж үнэлэгдэж байна.

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг, журмын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлж байх;
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.5 дахь заалт, 10¹ дүгээр зүйлд заасан дотоодын үйлдвэрийн чанар, стандартын шаардлага хангасан барааг худалдан авах;
- Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.4.3 дахь заалтад заасны дагуу худалдан авах ажиллагааг цахим систем

/www.tender.gov.mn/-ээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байх;

- Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт Сангийн яаманд хүргүүлэх, тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд урьдчилгаа төлбөр олгохгүй байх, хуульд заасан нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд үнийн тохируулга хийхгүй байх нь зүйтэйг анхаарна уу.

Үнэлгээний дүнг хавсаргав.

Тэргүүн дэд дарга



Б.ГАНБАТ